Барилгын засварын материал	15,748.0	15,786.0	38.0
Хүнсний материал	58.6	1,846.2	1,787.6
Бусад хангамжийн материал	70,843.8	123,079.6	52,235.8

Мал амьтад	20,314.0	15,261.5	-5,052.5
<b>Дүн</b>	<b>306,422.8</b>	<b>340,579.5</b>	<b>34,156.7</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 340,579.5 мянган төгрөг болж өмнөх оноос 34,156.7 мянган төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ 18,051.8 мянга, Эрүүл мэндийн төв 23,369.4 мянга, хүүхдийн цэцэрлэг 10,328.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

**Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	4,598.5	4,561.0	(37.5)	1.3
ЗДТГ	68,236.8	86,288.6	18,051.8	25.3
Соёл	30,810.3	32,955.3	2,145.0	9.7
ЭМТ	19,561.4	42,930.8	23,369.4	12.6
ОНХС			-	0.0
ЕБС	124,043.4	104,343.2	(19,700.2)	30.6
Цэцэрлэг	59,172.4	69,500.6	10,328.2	20.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>306,422.8</b>	<b>340,579.5</b>	<b>34,156.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 451,949.4 мянган төгрөгийн бараа материалын 393,006.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 58,943.3 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Тайлант онд Эрүүл мэндийн төв 45,431.3 мянга, ЕБС 7,704.6 мянга, хүүхдийн цэцэрлэг 5,807.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

**Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/**

Нэмэгдсэн	451,949.4	Хасагдсан	417,792.7
Худалдан авсан	393,006.1	Худалдсан, зарцуулсан	265,933.2
Хандиваар	58,943.3	шилжүүлсэн	116,552.9
Шилжүүлсэн авсан	0.0		1,882.7
бусад	-	бусад	33,424.0

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,357,474.1 мянга, эцсийн үлдэгдэл 7,673,926.1 мянган төгрөг болж 216,452.0 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	<b>7,290,694.1</b>	<b>7,607,146.1</b>	<b>316,452.0</b>	<b>99.1</b>
Барилга байгууламж, орон сууц	5,685,741.5	5,812,544.2	126,802.7	75.7
Тээврийн хэрэгсэл	254,760.0	282,810.0	28,050.0	3.7
Машин тоног төхөөрөмж	564,910.5	670,796.1	105,885.6	8.7
Тавилга эд хогшил	259,344.9	298,571.1	39,226.2	3.9
Зам гүүр байгууламж	199,800.0	209,800.0	10,000.0	2.7
Дуусаагүй барилга байгууламж	10,000.0	0.0	-10,000.0	0.0
Номын фонд	31,069.0	33,166.7	2,097.7	0.4
Бусад үндсэн хөрөнгө	285,068.3	299,458.1	14,389.8	3.9
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>66,780.0</b>	<b>66,780.0</b>	<b>0.0</b>	<b>0.9</b>
Программ хангамж	2,080.0	2,080.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	64,700.0	64,700.0	0.0	0.8
<b>НИЙТ ДҮН</b>	<b>7,357,474.1</b>	<b>7,673,926.1</b>	<b>316,452.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 353,302.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 76.1 хувь буюу 268,921.7 мянган төгрөгийг хөрөнгийн хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна. Үүнд ЗДТГ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 134,092.5 мянга, аймгийн ХХААГ-аас 2,381.5 мянга, ЕБС нь өмнөх оны авлагыг барагдуулан 9,950.0 мянга, 4,940.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэсэн, аймгийн ЗДТГ "Дэлхийн зөн" ОУБ-аас 13,190.0 мянга, Эрүүл мэндийн төв нь сумын ИТХ-ын 2021.12.31-ний өдрийн 22 дугаар тогтоолын дагуу 60,000.0 мянган төгрөгийн өртөгтэй моргийн барилга, бусад байгууллагаас хандиваар 26817.6 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

**Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	17,056.3	17,056.3	0.0	0.2
ЗДТГ	2,662,066.5	2,809,390.5	147,324.0	36.6
Соёл	1,186,671.5	1,198,396.5	11,725.0	15.6
ЕБС	1,551,409.1	1,623,880.1	72,471.0	21.2
Цэцэрлэг	1,389,387.3	1,405,875.3	16,488.0	18.3
Эмнэлэг	540,883.5	619,327.6	78,444.0	8.1
ОНХСан	10,000.0	0.0	-10,000.0	0.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>7,357,474.1</b>	<b>7,673,926.1</b>	<b>316,452.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 84,380.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 98,877.7 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 21,675.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байдлаар 148,369.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна. Мөн Эрүүл мэндийн төв нь аймгийн ИТХ-ын 102 дугаар тогтоолоор аймгийн Цагдаагийн газарт 26,850.0 мянган төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлсэн байна.

**Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/**

Нэмэгдсэн	353,302.0	Хасагдсан	36,850.0
Худалдан авсан	84,380.3	Худалдсан	
Хандиваар	98,877.7	Акталсан	
Шилжүүлэн авсан	148,369.0	Шилжүүлсэн	36,850.0
бусад	21,675.0	Бусад	

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,034.1 мянга, эцсийн үлдэгдэл 28,858.8 мянган төгрөг болж 23,824.8 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	<b>5,034.1</b>	<b>28,858.8</b>	<b>23,824.8</b>	<b>100.0</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	175.8	6,419.1	6,243.3	22.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,803.6	17,65.2	14,854.6	61.2
Байгууллагад төлөх өглөг	2,054.7	4,431.6	2,376.9	15.4
Хувь хүмүүст өгөх өглөг		350.0	350.0	1.2
<b>Дүн</b>	<b>5,034.1</b>	<b>28,858.8</b>	<b>23,824.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат ер төлбөр нь 28,585.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЭМД-ын санхүүжилт дутуу орсонтой холбоотой сумын Эрүүл мэндийн төвийн өглөг 22,907.9 мянган төгрөг буюу 79.4 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна  
Хүснэгт № 11. Нийт ер төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ		46.3	46.3	0.2
ЗДТГ		350.0	350.0	1.2
Соёлын төв		543.6	543.6	1.9
ЕБС		562.2	562.2	1.9
ЭМТ	3,644.1	22,907.9	19,263.8	79.4
ОНХС		2,700.0	2,700.0	9.4
Цэцэрлэг		358.9	358.9	1.2
СХСан	1,390.0	1,390.0	-	4.8
<b>ДҮН</b>	<b>5,034.1</b>	<b>28,858.8</b>	<b>23,824.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,802,474.7 мянга, эцсийн үлдэгдэл 6,837,649.6 мянган төгрөг болж, 35,174.8 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,248,819.7	1,248,819.7	-	18.3
Өмч: - төрийн	1,248,819.7	1,248,819.7	-	18.3
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>4,348,342.1</b>	<b>4,383,516.9</b>	<b>35,174.8</b>	<b>64.1</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,205,312.9	1,205,312.9	0.0	17.6
<b>Дүн</b>	<b>6,802,474.7</b>	<b>6,837,649.6</b>	<b>35,174.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн данс 35,174.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 35,174.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн хуралдаанаар 2/14 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 51,800.0 мянга, хүү торгуулийн орлогыг 6,000.0 мянга, нийт 57,800.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	51,800.0	81,416.7	29,194.3	157.2
ИОТХ	3,000.0	25,681.3	22,681.3	856.0
Бууны татвар	1,800.0	1,960.0	160.0	108.9
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	2,924.4	924.4	146.2
Хадгаламжийн хүүгийн орлого	23,500.0	23,785.0	285.0	101.2
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.0	3,954.4	954.4	131.8
Газрын төлбөр	2,000.0	2,090.3	90.3	104.5

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,000.0	18,068.8	3,068.8	120.5
Ус рашаан	1,000.0	2,230.0	1,230.0	223.0
ТТАМАТөлбөр	500.0	300.0	(200.0)	60.0
Бусад татвар		422.3		
2.Татварын бус орлого	6,000.0	6,167.9	167.9	102.8
2.1.Хүү торгуулийн орлого	6,000.0	6,167.9	167.9	102.8
<b>Нийт дүн</b>	<b>57,800.0</b>	<b>87,584.6</b>	<b>29,362.3</b>	<b>161.5</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 157.2 хувь буюу 29,194.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 22,681.3 мянга, улсын тэмдэгтийн хураамж 924.4 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 285.0 мянга, ҮХХБО 954.4 мянга, газрын төлбөр 90.3 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3,068.8 мянга, ус рашаан 1,230.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна. Харин ТТАМАТ 200.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1,839.6 мянган төгрөгийн орлого орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 78,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 52,921.7 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,781,647.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,411,966.3 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 2,272,856.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 139,110.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ний өдрийн 2/14 дугаар тогтоолоор нийт 2,711,643.3 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	65,228.6	65,228.6	0.0
Засаг даргын Тамгын газар	464,350.0	416,891.8	47,458.2
Сургууль	1,100,052.0	864,317.6	235,734.4
Цэцэрлэг	342,772.8	342,772.8	0.0
Эрүүл мэндийн төв		437,525.6	-437,525.6
Соёлын төв	104,126.0	104,126.0	0.0
Сум хөгжүүлэх сан		213,032.0	-213,032.0
Орон нутгийн хөгжлийн сан		267,748.9	-267,748.9
<b>Нийт дүн</b>	<b>2,076,529.4</b>	<b>2,711,643.3</b>	<b>-635,113.9</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 2/14 дүгээр тогтоолоор анх 2,711,643.3 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.22-ний өдрийн 3/20 дугаар тогтоолоор 81,092.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 11,087.0 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2,781,647.8 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,472,784.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 257,796.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 687,065.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 57,800.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 88,784.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 28,929.7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 188,487.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 8,228.6 мянган төгрөгөөр дутуу, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 2,569.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 37,224.2 мянга, орон нутгийн төсөвт 3,787.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улс	ОН
ЗДТГ	469,519.9	467,757.5	1,762.4	99.6	-	597.1
ИТХ	67,228.6	66,731.5	497.1	99.3	-	2,602.0
Соёлын төв	103,308.4	102,720.2	588.2	99.4	-	588.2
Сум хөгжүүлэх сан	213,032.0	22,959.0	190,073.1	10.8	-	-
Сургууль	926,802.7	890,325.8	36,476.9	96.1	32,411.6	-
эцэрлэг	296,481.7	288,919.5	7,562.2	97.4	4,812.7	-
ЭМТ	437,525.6	433,442.9	4,082.7	99.1	-	-
ОНХС	267,748.9	139,110.0	128,638.9	52.0	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2,781,647.8</b>	<b>2,411,966.3</b>	<b>369,681.5</b>	<b>86.7</b>	<b>37,224.2</b>	<b>3,787.3</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 36,476.9 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 128,638.9 мянга, сум хөгжүүлэх сангийн зардлыг зээл олгоогүйтэй холбоотой 190,073.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 91,000.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 28,931.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,909.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж

207,530.2 мянган төгрөгийг зарцуулж 1,673.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,000.0	16,569.6	28,035.7	4,953.1	189,485.3	240,043.7
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0	16,569.6	28,035.7	4,953.1	40,441.8	91,000.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого					149,043.5	149,043.5
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	969.0	16,537.2	28,03.7	4,953.1	187,875.4	238,370.4
Бараа үйлчилгээний бусад зардал		1,909.2				1,909.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	969.0	14,628.1	4,057.8		187,875.4	207,530.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			23,977.9	4,953.1		28,931.1
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	<b>31.1</b>	<b>32.3</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>1,609.9</b>	<b>1,673.3</b>

Эх сурвалж: Баянговь сумын 2021 оны санхүүгийн нэгжлэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 63,000.0 төгрөгөөр тодотгон баталж 62,947.8 мянган төгрөгийг зарцуулж 52.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 67.7 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал, малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 86.6 хувийг, 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд 2.9 хувийг, 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт 10.5 хувийг тус тус зарцуулжээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 107 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 83.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,781,647.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,411,966.3 мянган төгрөгийг зарцуулж, 86.7 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 9 нэр төрлийн орлогоор 57,800.0 төгрөг төвлөрүүлэхээс 87,584.6 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого хувь буюу 29,362.3 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 1 нэр төрлийн орлого 200.0 мянган төгрөг тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянговь сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Баянговь сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Зөрчилгүй	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан			Хягаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЕБСургууль	1	1	1		1	1				
Хүүхдийн цэцэрлэг	1	1	1		1	1				
ЗДТГ	1	1	1		1	1				
ИТХурал	1	1		1						
Соёлын төв	1	1		1						
ЭМТ	1	1	1		1	1				
ОНХС	1	1		1						
СХС	1	1		1						
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагууд 4 байгууллага зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 551,963.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 30,836.0 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 35,209.8 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 11,880.9 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 474,036.6 мянган төгрөгийн 14 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн зөрчил</b>										
ЕБСургууль	6	22,022.6	1	836.0	1	7,363.0			4	13,823.6
Хүүхдийн цэцэрлэг	1	2,647.9			1	2,647.9				
ЗДТГ	2	1,204.8			1	480.0	1.00	724.8		
ОНХСан	3	163,900.0	1	30,000.0					2	133,900.0

ЭМТ	0	-								
СХС	3	1,390.0			1	1,390.0			2	-
Соёлын төв	0	-								
СТА зөрчлийн дүн	15	191,165.3	2	30,836.0	4	11,880.9	1.00	724.8	8	147,723.6
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЕБСургууль	0	-								
Хүүхдийн цэцэрлэг	2	37,763					1	34,485	1	3,278.2
ЗДТГ	2	190,365							2	190,364.8
ОНХСан	1	132,670							1	132,670.0
ИТХурал	1	-							1	-
СХС	0	-								
Соёлын төв	0	-								
ЭМТ	1	-							1	-
Нийцлийн аудитын дүн	7	360,798	-	-	-	-	1	34,485	6	326,313.0
Нийт дүн	22	551,963	2	30,836	4	11,880.9	2	35,210	14	474,036.6

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 191,165.3 мянган төгрөгийн 15 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 360,798.0 мянган төгрөгийн 7 зөрчил тус тус илэрсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 129 мэдээллээс 65 мэдээллийг хугацаанд нь, 62 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	10	10	4	4	2
2	Хагас жил	3	3	2	1	
3	Улирал бүр	2	8	5	3	
4	Сар бүр	3	36	15	21	
5	Тухай бүр	6	72	39	33	
	Нийт	24	129	65	62	2

Эх сурвалж. Баянговь сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Баянговь сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Баянговь сумын ЕБС нь Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,834.8 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан, тогтмол зардалд 99,804.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 95.9 хувь буюу 95,738.6 мянган төгрөгийг зарцуулан Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Баянговь сумын ЗДТГ нь байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсөв 35,909.7 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан нь төсвийн хэмнэлтийн талаар авах арга зарим арга хэмжээний тухай тогтоолын дагуу 3,590.7 мянган төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байна.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 10,285.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ний өдрийн 79 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	10,285.0	3	10,285.0			100.0
Нийт	3	10,285.0	3	10,285.0			100.0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй. Харин ЭМТ-ийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 184,586.5 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид авлагын тооцоог тухайн онд багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй 8,909.7 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлж байна.

##### 4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх.

#### 2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 2/14 дүгээр тогтоолоор анх 2,711,643.3 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.22-ний өдрийн 3/20 дугаар тогтоолоор 81,092.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар ЕБС-ийг 20,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хүүхдийн цэцэрлэгийг 31,587.0 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2,781,647.8 мянган төгрөг болжээ. Харин Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 11,087.0 мянган төгрөгөөр буурсан байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх.

#### 3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 551,663.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

#### 4. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 129 мэдээллээс 65 мэдээллийг хугацаанд нь, 62 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулж, түүнд тавих Төрийн сангийн хяналтыг сайжруулах

#### 5. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой.

Илрүүлэлт Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 87584.6 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 86052.9 мянган төгрөг буюу 1,531.7 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын санхүүгийн албаны дарга татварын байцаагчтай тооцоо нийлж аймгийн Татварын хэлтэст татварын мэдээг үнэн зөв мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.  
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо</b> 2022	<b>Аудитын нэр:</b>	Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b> БНА-2022/15/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		Баянговь сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
<b>ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:</b>					
1	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан Э.Пүрэвжаргал
2	Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 11,084.0 мянган төгрөгөөр буурсан байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.	11,087.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан Э.Пүрэвжаргал
3	Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 538,139.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан Э.Пүрэвжаргал
4	Шилэн дансны цахим хуудсанд тайланг хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 85 мэдээллийг хугацаанд нь, 68 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан Э.Пүрэвжаргал
5	Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 87584.6 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 86052.9 мянган төгрөг буюу 1,531.7 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.	1,531.7	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан Э.Пүрэвжаргал
<b>ДҮН</b>		<b>12,618.7</b>			

оОо

**5. Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт** /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Алдаа, зөрчлөлтийг гурвал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Огноо нэр
А	2	3	4	5	
Засаг даргын Тамгын газар		191,569.50			
1	Тайлант оны эцэст 744.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс ажиллагсад олгосон цалингийн урьдчилгааны үлдэгдэл 480.0 мянган төгрөг байна.	480.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Мөрөндалай
2	Баянговь сумын ЗДТГ-ын дарга Д.Отгонжаргал нь 2017 оны 04 дүгээр 03-ны өдрийн 11 дүгээр тушаалаар санхүүгийн албаны дарга Б.Энхжаргалыг ажлаас халсан ба иргэн б.Энхжаргал нь Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандаж 2019.01.15-ны өдрийн 121/ШШ2019/001/3 дугаар шийдвэрээр ажилд эгүүлэн тогтоолгон, НДШ-ийг нөхөн төлүүлэх шийдвэр гарсаны дагуу 2017.04.03-2018.05.29-нийг хүртэлх хугацааны ажил олгогчоос төлөх 724.7 мянган төгрөгийг тайланд оны нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлсөн байна.	724.7	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Мөрөндалай
3	Тус байгууллага нь 2021 онд нийт 547,922.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 113 мэдээллийг хугацаанд мэдээлж 31 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 мэдээлэл мэдээлээгүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 мөнгөн гүйлгээний 149,529.7 мянга, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 37,244.4 мянган төгрөгийн 6 мэдээл	186,774.1	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Мөрөндалай
4	Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсөв 35,909.7 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан нь төсвийн хэмнэлтийн талаар авах арга зарим арга хэмжээний тухай тогтоолын дагуу 3,590.7 мянган төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байна.	3,590.7	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Мөрөндалай
Ерөнхий боловсролын сургууль		22,022.6			
1	Сумын төрийн сангийн төлөөлөгчийн буруугаас 2021.12.15-ний өдрийн нийгмийн даатгалын шимтгэлийн гүйлгээг давхардуулан оруулснаас оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлтийг төсөвт төвлөрүүлэлгүй, төвлөрсөн санд шилжүүлж, авлага үүссэн байна.	7,363.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох Ж.Золжаргал
2	Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2021.11.29-ний өдөр "Мөнхөд дэлгэрэх" ХХК-д үдийн цайны зардалд шилжүүлсэн 5,785.4 мянган төгрөгийн зарлагыг мэдээлээгүй орхигдуулсан байна.	5,785.4	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох Ж.Золжаргал
3	Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 836.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.	836.0	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох Ж.Золжаргал
4	Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,834.8 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан, тогтмол зардалд 99,804.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 95.9 хувь буюу 95,738.6 мянган төгрөгийг зарцуулан Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох Ж.Золжаргал
5	Тайлант онд зарцуулсан ковидын төстийн зарцуулалтыг сургуулийн эмч бүрэн хөтлөөгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох Ж.Золжаргал
6	Оны эцэст байгууллагын даргын 54 дүгээр тушаалаар байгууллагын бүх албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 25 хувиар хавтгайруулан олгож, 8,038.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.	8,038.2	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох Ж.Золжаргал
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал		-			

**Баянговь сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд нийт 67228.6 мянган төгрөгийн 151 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Чимэдцэрэн Э.Мөрөндалай
Сум хөгжүүлэх сан		1,390.0			
1	Баянговь сумын сум хөгжүүлэх санд 2020.12.31-нээр 135832.1 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж, 2021.01.01-2021.12.20-ний хооронд зээл, зээлийн эргэн төлөлтөөр 29727.7 мянган төгрөг орж, 2021.12.20-ний байдлаар 165359.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба тус сангаас 2021 онд зээл олгоогүй, олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан С.Бямбажаргал
	Санхүүгийн тайланд авлагаар бүртгэгдсэн зээлдэгч нарын хувийн хэргийн бүрэлдэхүүн хэсэг хангалтгүй, баримт материал дутуу байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан С.Бямбажаргал
	Санхүүгийн тайланд оны эхэнд 1,390.0 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэйг тодруулахад ОНХС-аас малжуулах зээлийн эргэн төлөлтөөр 2018 онд 650.0 мянга, 2019 онд 650.0 мянган төгрөгийн орлого орсон, 90,0 мянган төгрөг нь хэзээ үүссэн өглөг нь тодорхойгүй байна.	1,390.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан С.Бямбажаргал
Орон нутгийн хөгжлийн сан		296,270.0			
1	Ишигний эвэр рашаан тохижуулах 10.0 сая төгрөг, Орон нутаг судлалын танхим 10.0 сая төгрөг Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж 10.0 сая төгрөгийн ажлыг хүлээн аваагүй байж санхүүжилт олгосон	30,000.0	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан С.Бямбажаргал
2	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг ажлын хэсэг байгуулан хүлээн авч сумын ИТХ-аар эзэмшигчийг тогтоолгон 116.0 сая төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй байна.	116,000.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан С.Бямбажаргал
3	ОНХС-ийн хөрөнгөөр 17.9 сая төгрөгийн өвс тэжээл худалдан авсан боловч өвс тэжээлийн тооцоо бодож баталгаажуулаагүй, өвс тэжээлээс тайлант онд 370.0 мянган төгрөгийн орлого орсон байна.	17,600.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан С.Бямбажаргал
4	Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 т заасан 132,670.0 мянган төгрөгийн мэдээллийг хоцроосон	132,670.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Мөнхсайхан С.Бямбажаргал
Эрүүл мэндийн төв		-			
1	Шилэн дансны цахим системд нийт төрлийн 396,987.8 мянган төгрөгийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлхээс 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өлзийжаргал Д.Өнөрмандах
Хүүхдийн цэцэрлэг		40,411.1			
1	Шилэн дансны цахим системд нийт 288,919.4 мянган төгрөгийн 17 төрлийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлхээс 34,485.0 мянган төгрөгийн 45 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна	34,485.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Гансмаа Ж.Золжаргал
2	Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 35,307.5 мянган төгрөгөөр, тодотголоор 35,307.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 32,557.9 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 3,278.2 мянган төгрөг буюу 14.7 хувь хэмнэсэн нь тогтмол зардлыг 20 хувь хэмнэх гэсэн Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.	3,278.2	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Гансмаа Ж.Золжаргал
3	Тайлант онд НДШ төлөлтийн мэдээний кодын өөрчлөлтөөр тухайн байгууллагад илүү төлсөн шимтгэлийг суутган тооцохоор бичилт хийсэн байхад 12-р сард 2,647.9 мянган төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн байна.	2,647.9	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Д.Гансмаа Ж.Золжаргал
Нийт дүн		551,663.2			

ооо